БАТЛАВ
“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ”
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
Д.ОЮУНБОЛД

“АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ЖИШИГ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА ЗЗБНбД 31-008-2016“-Г ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 10 сарын 06-ны өдөр № 11/2025 Улаанбаатар хот

1. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага

- Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “АЛСЫН ХАРАА-2050”
- Монгол Улсын Их хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”
- “Авто замын норм нормативын сангийн хөрөнгөөр 2025-2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө”.
- Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын үйлдвэрлэлийн болон төсвийн жишиг нормыг шинэчлэн боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд материалын шинжилгээний давтамжтай холбоотойгоор гарсан шинэчлэх санал.
- Авто замын салбарт шинэ техник, технологи нь тодорхой өөрчлөлтийг оруулж байна. Ялангуяа туршилт шинжилгээний материалууд нэвтэрч үйлдвэрлэлд ашиглагдаж эхэлсэнтэй холбоотой туршилтын давтамж, хийгдэх шинжилгээний тоог бодитой, чанарын шаардлага алдагдуулахгүй тооцох нөхцөл шаардлага үүссэн.
- Авто зам, замын байгууламжийн хийц, технологи, материалд орчин үеийн шинэ дэвшилтэт техник, технологи нэвтэрч байгаатай холбогдуулан эдгээр техник, технологийн стандарт, техникийн шаардлагыг одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй жишиг техникийн шаардлагад шинээр бүлэг, зүйлүүд нэмж оруулах.

- Жишиг техникийн шаардлага гэдэг бол зам барилгын ажил гүйцэтгэх үеийн барилгын ажлын чанарт тавигдах хамгийн бага шаардлага бөгөөд тухайн төслийн онцлогоос хамаарч зураг төсөл зохиогч байгууллагууд уг жишиг техникийн шаардлагын үзүүлэлтээс чанарын шаардлагыг бууруулахгүйгээр төслийн техникийн шаардлагыг гарган батлуулах шаардлагатай.
- Авто замын салбарт шинээр нэвтэрч буй орчин үеийн шинэ дэвшилтэт техник, технологийг хамарсан авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлагатай болсон байх.

2. Зөвлөх үйлчилгээний зорилго	• Зам, тээврийн сайд (хуучин нэрээр)-ын 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 186 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Авто зам, замын барилгын ажлын жишиг техникийн шаардлага ЗЗБНбД 31-008-2016”-ын дахин хянаж, шинээр боловсруулах, шинэчлэх, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад баримт бичгүүд тэдгээрийн нэр томьёо тодорхойлолттой уялдуулан боловсруулах.
3. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд ашиглах, дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмууд	• “Авто замын тухай хууль”, • Бусад холбогдох хууль, тогтоомж, • Хууль тогтоомжийг дагаж гарсан журам, батлагдсан маягт
4. Зөвлөх үйлчилгээний ажил, үүрэг	• Авто замын хучилтын хийцийн нэг төрөл болох хөшүүн хийцийг барьж байгуулахтай холбоотой жишиг шаардлагыг норм нэмж тусгах. • Төслийн үр дүнд гадаад орнуудад мөрдөж буй дэвшилтэт, техникийн баримт бичгийг жишиг болгон, Монгол орны байгаль цаг, уурын нөхцөл, зам цаг уурын бүсчлэлд нийцүүлэн хийгдсэн судалгаа, тооцоо, шинжилгээний үр дүнд жишиг техникийн шаардлагыг шинэчлэн боловсруулсан байна. • Авто замын барилга, засварын болон бусад холбогдох шинээр гарсан стандарт, норм бусад техникийн баримт бичгүүдтэй нийцүүлж боловсруулсан байна. • “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага ЗЗБНбД 31-008-2016”-д орсон лабораторийн туршилт шинжилгээний давтамжийн тоо, ажлын тоо хэмжээ болон туршилт, шинжилгээний ажлын стандарт, аргачлалын талаар нарийвчилсан тооцоолол, судалгаа хийх. • Авто замын салбарт шинээр нэвтэрсэн техник, технологиудтай уялдуулан шинэчлэх. • “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага ЗЗБНбД 31-008-2016”-ын Бүлэг 800 хоолой ба ус өнгөрүүлэх бусад байгууламж, Бүлэг 900 Гүүрийн ажил гэсэн бүлгүүдийн нэмэлт шинэчлэлтийг боловсруулахдаа ЗТХСайдын 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/123 дугаар тушаалаар батлагдсан “Гүүр ба хоолойн барилгын ажлын жишиг техникийн шаардлага ЗЗБНбД 33-001-2021”-ын Хоолой, ус зайлуулах байгууламж, гүүрэн байгууламжийн ажлын шаардлага, барих арга аргачлалыг хооронд нь уялдуулах
5. Зөвлөх үйлчилгээний	• Эхлэл буюу судалгаа, төлөвлөгөө гаргасан тайлан • Дунд шатны тайлан

баримт бичгийн бүрдэл:	• Эцсийн буюу нормын төсөл /“Авто зам, замын барилгын ажлын жишиг техникийн шаардлага ЗЗБНбД 31-008-2016”-ын төслийн үе шатны тайлан, редакцын ажлын хэсгийн санал дүгнэлт, хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж./
6. Санал болгож буй арга зүй	• Ажиглалт харьцуулалтын арга • Олон улсын төсөл хөтөлбөрүүдэд ашиглагддаг жишиг техникийн шаардлага, норматив бичиг баримт
7. Зөвлөх үйлчилгээний үр дүн	• “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага” шинэчлэн боловсруулагдсан байна.
8. Зөвшилцөх байгууллага	• Зам, тээврийн яам, • Нийслэлийн замын хөгжлийн газар
9. Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх багт тавигдах шаардлага	• Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх баг 5-оос доошгүй хүнтэй ажиллах ба багийн гишүүдэд дор дурдсан үндсэн шаардлагууд тавигдана. Үүнд: • Зөвлөх багийн ахлагч -1: Зам, барилгын чиглэлээр МУ-ын зөвлөх инженер зэрэгтэй, Тухайн мэргэжлээрээ 20-аас доошгүй жил ажилласан, авто замын гадаад, дотоодын төслүүдэд багийн ахлагчаар ажиллаж байсан. Авто зам, замын байгууламжийн стандарт, норм норматив, техникийн баримт бичиг боловсруулж байсан туршлагатай байх. • Авто замын инженер-2: Авто замын салбарт 15-аас доошгүй жил ажилласан, үүнээс авто замын олон улсын төсөл хөтөлбөрүүдэд 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай. Зам барилгын төслийн олон улсын жишгийн дагуу төлөвлөж тооцох, энэ чиглэлээр норм дүрэм, техникийн шаардлага боловсруулах, тооцоо, шинжилгээ хийх мэдлэг, чадвартай байх. • Судлаач -3: Авто замын барилга угсралт, лабораторийн туршилт судалгаа, төслийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүх талын туршлагатай, жишиг техникийн шаардлагыг шинэчлэн боловсруулах онол арга зүйн мэдлэг чадвартай, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг 3-аас доошгүй жил хийж судалгаа шинжилгээний бүтээлээ гаргасан мэдлэг туршлагатай байх
10. Зөвлөх үйлчилгээний ажлын хэрэгжүүлэх хугацаа:	• 12 сар (Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш)
11. Зөвлөх үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр:	• “Авто замын норм нормативын сан” • 123,600,000 сая төгрөг.
12. Төслийн онцгой нөхцөл:	• Зөвлөх үйлчилгээний үе шатны тайланг “Эрдэм шинжилгээний ажлын тайлан. Бүтэц шаардлага” MNS 2492:2004 стандартын дагуу боловсруулах;

- Салбарын мэргэжлийн холбоод, төрийн болон төрийн бус байгууллага, салбарын зөвлөх инженерүүдээс албан ёсоор санал авах, саналыг төсөлд хэрхэн тусгасан талаар саналын товчоо, тайлбар танилцуулга гаргах;
- Төслийн боловсруулалтын явцад салбарын байгууллага, ИТА нарыг хамруулсан 2-оос доошгүй удаа нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, төсөлд санал авах;
- Үе шатны тайлан, нормын эцсийн төсөлд Захиалагчаас томилогдсон салбарын мэргэжлийн Зөвлөх, Мэргэшсэн 3-аас доошгүй инженерээр редакц, шүүмж хийлгэх;
- Нормын эцсийн төсөл (Редакц, шүүмжийн ажлын хэсгийн төслийн эцсийн тайланг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар эцсийн дүгнэлт гарсан байх)-ийг Зам тээврийн яамны Авто замын салбарын Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөл болон Зам, тээврийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж зөвлөмжийн дагуу шаардлагатай өөрчлөлт, боловсруулалтыг хийж, танилцуулгын хамт батлуулахаар Захиалагчид хүргүүлэх;
- Зөвлөмжийн дагуу шаардлагатай боловсруулалтыг хийн, танилцуулгын хамт батлуулахаар Захиалагчид хүргүүлэх. Төслийн хүрээнд боловсруулсан, худалдан авч ашигласан бүх цахим болон хэвлэмэл материал, тоног төхөөрөмж, программ хангамж зэргийг эх хувиар эцсийн тайлангийн хамт Захиалагчид хүлээлгэн өгөх;
- Захиргааны ерөнхий хуулийн 61-р зүйлийн 61.4 дэх хэсэгт заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж, бүртгүүлэхэд Захиалагчтай хамтран ажиллах.
- Судалгааны ажлын хүрээнд цуглуулсан мэдээлэл, судалгааны үр дүн, тайлан, боловсруулагдсан аливаа программ хангамж, түүний эх код нь “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн 17.2 18 дугаар зүйлийн дагуу Зам, тээврийн хөгжлийн төвийн өмч болно.

ХЯНАСАН:
Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн дарга Э.БАЛТ

БОЛОВСРУУЛСАН:
Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн мэргэжилтэн О.ДОЛГИОН